

Golomt Capital®

БОНДЫН

ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ



2025.02.12



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БОНД

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Номад	2026.04.07	5.345%	5.08%
Хүннү	2028.01.19	6.37%	6.28%
Монгол 29	2029.06.05	6.75%	6.58%
Монгол 31	2031.07.07	5.35%	7.00%

Эх сурвалж: Bloomberg

Монгол Улсын олон улсын зах зээлд гаргасан Засгийн газрын бондуудын өгөөж 5.08%-7.0% хооронд хэлбэлзэж, дунд болон урт хугацааны тогтвортой хөрөнгө оруулалт хайж буй хөрөнгө оруулагчдад боломж олгож байна.



КОМПАНИЙН БОНД (АМ.ДОЛЛАР)

Нэр	Дуусах хугацаа	Купон	Өгөөж
Хөгжлийн банк (DBM)	2026.03.07	11.00%	7.26%
Энержи Ресурс (MMC)	2026.09.13	12.50%	6.58%
МИК (MIK)	2027.01.18	11.50%	11.04%
Голомт Банк (GLMT)	2027.05.20	11.00%	8.63%

Эх сурвалж: Bloomberg

Компанийн ам.долларын бондуудын өгөөж 6.58%-11.04%-ийн түвшинд хэлбэлзэж, эрсдэлийг давж өндөр өгөөж хайж буй хөрөнгө оруулагчдын сонирхлыг татаж байна. Голомт Банк олон улсын зах зээлд жилийн 11%-ийн хүүтэй, 2027.05.20-нд хаагдах 300 сая ам.долларын бондыг амжилттай гаргасан бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар худалдан авах боломжтой хэвээр байна.

Монгол Улс шинэ бонд гаргах, тендер санал зарлах ажиллагааг эхлүүлэв

Монгол Улсын Засгийн газар S&P (B+), Fitch (B+), Moody's (B2) үнэлгээтэй Номад (MONGOL 26) болон Хүннү (MONGOL 28) бондуудыг худалдан авах тендер санал зарлаж, зэрэгцэн шинэ ам.долларын бонд гаргах төлөвлөгөөгөө зарлалаа. Тендер саналаар Засгийн газар 2026 оны бондыг нэрлэсэн үнээр худалдан авах, 2028 оны бондыг 106.5%-ийн үнээр (хязгаарлагдмал хэмжээгээр) худалдан авахаар санал болгож байна. Шинэ бондоос орж ирэх хөрөнгө нь дээрх худалдан авалтыг санхүүжүүлэх гол эх үүсвэр байх юм. Тендер саналын үйл явц 2025 оны 2-р сарын 14-ний 17:00 (Нью-Йорк цаг) хүртэл үргэлжилнэ. Шинэ бондыг 2025 оны 2-р сарын 18-нд үнийн нөхцөлийг танилцуулахаар төлөвлөж байна.



Р.ДАРХАНБАЯР
Хөрөнгийн удирдлага,
судалгааны газрын захирал



АМ.ДОЛЛАРЫН БОНДЫН СУУРЬ МЭДЭЭЛЛҮҮД

АНУ-ын 20 жилийн засгийн газрын бондын өгөөж 4.808%-д тогтворжиж, 4.680%-ийн дэмжлэгийн түвшнээс дээш өслөө. Өмнө нь 5.08%-ийн эсэргүүцлийг сорьсон ч давж чадаагүй нь богино хугацаанд өсөлтийн хязгаар байгаа гэдгийг илтгэж байна. Холбооны Нөөцийн Банк бодлогын хүүг яаран бууруулахгүй гэсэн шийдвэр болон Трампын тарифын нөлөөнөөс шалтгаалан 5.08% болон 5.42%-руу өсөх боломжтой.

График 1. АНУ-ын урт хугацаат бондын өгөөж

Golomt_Capital published on TradingView.com, Feb 12, 2025 10:32 UTC+8

United States 20 Year Government Bonds Yield, 1D, TVC O4.811% H4.811% L4.797% C4.807% +0.002 (+0.04%) +0.002 (+0.04%)



Эх сурвалж: Tradingview

2024 онд манай улсын сарын дундаж импортын хэмжээ 960 сая ам.доллар болж, 2023 оны 700 сая ам.доллараас 37%-иар өссөн. Өмнөх онуудад валютын нөөцийн шаардлагатай хэмжээ 3.3 тэрбум ам.доллар байсан бол одоо сарын импортын өсөлт 960 сая ам.доллар байгаагаас шалтгаалж шаардлагатай хэрэгцээ 4.3 тэрбум ам.доллар болж нэмэгдсэн. Иймд ГВАН өссөн ч импортын хэрэглээ өсөж буй тул ам.долларын ханш 2025 он гарснаар аажмаар чангарч байна. Өнөөдрийн байдлаар ам.доллар 3,457.45 төгрөгрт хүрч судраад байна.

График 2. Ам.долларын төгрөгтэй харьцах ханш

Golomt_Capital published on TradingView.com, Feb 12, 2025 10:49 UTC+8

U.S. DOLLAR / MONGOLIAN TUGRIK, 1W, ICE 3,457.45 +2.23 (+0.06%) 0.00 (0.00%)



Эх сурвалж: Tradingview



БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Биржийн бус зах зээлийн долоо хоногийн арилжааны тойм

Өнгөрсөн долоо хоногт биржийн бус зах зээлд нийт 99,967 ширхэг үнэт цаас 47,847,920,226 төгрөгийн үнэлгээтэй, мөн 960 ширхэг үнэт цаас 961,003.07 ам.доллараар арилжаалагдсан байна. Үүнээс анхдагч зах зээлд 21,700 ширхэг үнэт цаас 21,700,000,000 төгрөгөөр, 930 ширхэг үнэт цаас 930,000.0 ам.доллараар арилжаалагдсан бол хоёрдогч зах зээлд 78,267 ширхэг үнэт цаас 26,147,920,226 төгрөгөөр, 30 ширхэг үнэт цаас 31,003.07 ам.доллараар арилжаалагдсан байна.

Биржийн бус зах зээлийн Бүртгэлийн хороо 1 үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулж, 1 үнэт цаасыг буцааж, 4 үнэт цаасыг бүртгэлээ.


Эх сурвалж: Otc.mn

Биржийн бус зах зээлийн бондын өгөөжийн муруй

Бондын өгөөжийн муруй нь зах зээлд гарч буй бондуудын хугацаа болон өгөөжийн хамаарлыг нь илтгэдэг. Өгөөжийн муруйг дараах зорилгоор ашиглах боломжтой. Үүнд:

- Үнэт цаасны өгөөжийн хувь үнэт цаасны хугацаанаас хамааран хэрхэн ялгаатай тогтож байгааг мэдэх
- Шинээр гаргах үнэт цаасны үнэ ханш, өгөөжийг тогтоох жишиг хувь болох
- Бусад бондын өгөөжтэй харьцуулан шийдвэр гаргах боломжийг олгодог юм.

График 2. Бондын өгөөжийн муруй (2024.10-р сард бодлогын хүү өөрчлөгдсөнөөс хойш)



БОНДЫН ЗӨВЛӨХҮҮД

8665-1177 | 8665-4422 | 8083-6622 | 8888-9183